

ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ 2019-2021 ОНД ХЭРЭГЖИХ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хамтын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа тул 2019 оны...*09*... сарын ...*02*... өдөр бүртгэв.

УЛААНБААТАР ХОТ

2019 ОНЫ *09* САРЫН ...*02*... ӨДӨР

БҮРТГЭВ.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

2019 оны ...⁰⁹...сарын ...⁰²...-ны өдөр

ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ 2019-2021 ОНД
ХЭРЭГЖИХ ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Хэлэлцээрт оролцогч талууд:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

Зам, тээврийн хөгжлийн яам

АЖИЛ ОЛГОГЧДЫГ ТӨЛӨӨЛЖ:

Иргэний нисэхийн ерөнхий газар, "МИАТ" ТӨХК,
"Изинис эйрвэйз" ХХК

АЖИЛТНЫГ ТӨЛӨӨЛЖ:

Монголын тээвэр, холбоо, газрын тосны
ажилтны үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 19 зүйлийг тус тус үндэслэн Иргэний нисэхийн салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын нийтлэг эрхийн хэм хэмжээг тогтоож боловсронгуй болгох, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйл ажиллагааны харилцан үр ашигтай байдлыг хангах, "Хөдөлмөрийн тухай хууль"-аар шууд зохицуулагдаагүй харилцааг зохицуулах зорилгоор оролцогч талууд хэлэлцээ хийж, харилцан тохирч энэхүү хамтын хэлэлцээрийг байгуулав.

1.2. Хамтын хэлэлцээр нь талууд гарын үсэг зурж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж, 2 жилийн хугацаанд хэрэгжүүлж дуусахад талууд шинээр санал гаргаагүй, хэлэлцээр байгуулаагүй бол хугацааг дахин 2 жилээр хэрэгжүүлнэ.

1.3. Талууд харилцан тохиролцооноор хамтын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд хэлэлцээрийн талуудад ажлын 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж шийднэ.

1.4. Иргэний нисэхийн салбарын хувийн хэвшлийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж, компаниудын өмчийн харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нөхцөлд хамтын хэлэлцээр хүчин төгөлдөр байх бөгөөд энэ хэлэлцээрийн заалтуудаас илүү нөхцөлөөр тохиролцсон хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээний заалтууд хэвээр мөрдөгдөнө.

1.5. Хэлэлцээрийн биелэлтэд талуудын төлөөлөгчид, мөн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.


1.6. Талууд хамтран буюу дангаар уг хэлэлцээрийн биелэлтийн явц байдлыг жил тутамд гаргаж, хамтарсан хурлаар хэлэлцэж, мэдээллийг иргэний нисэхийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, компаниудын хамт олонд хүргэж байна.

1.7. Талууд Хамтын хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, биелүүлэхийг шаардах, шаардлагатай тохиолдолд хамтын маргаан үүсгэх зэргээр идэвхтэй ажиллана.

1.8. Хамтын хэлэлцээр нь өмнөх хүрсэн түвшинг тасралтгүй сайжруулах зарчим баримтална.

ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР

2.1 Ажлын байрыг олноор цөөрүүлэх, хөдөлмөрлөх нөхцөл байдлыг дордуулахад хүргэх орон тоо, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ аж ахуйн нэгж байгууллага /ажил олгогч/



нь 45 хоногийн өмнө холбогдох үйлдвэрчний эвлэлийн байгууллагад урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль, ёсны ашиг, сонирхлыг хангах, нийгмийн хамгааллын талаар гэрээ байгуулж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бичгээр мэдэгдэнэ.

2.2 Салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулах ба байнгын ажлын байранд ажиллаж буй ажилтны хөдөлмөрийн гэрээг хугацаагүйгээр байгуулна.

2.3 Байгууллагын түвшинд тухайн жилийн цалин хөлс, нийгмийн хамгаалалтай холбогдсон төсвийн төсөл боловсруулах, зарцуулах асуудлаар Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын саналыг харгалзаж үзнэ.

2.4 Салбарын ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төслийг боловсруулж хэрэгжүүлэхдээ тухайн ажил олгогчдын болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагын оролцоог хангаж ажиллана.

ГУРАВ. ЦАЛИН ХӨЛСНИЙ ТАЛААР

3.1 Үндсэн цалин, хийснээр хөлс авдаг ажилтны гүйцэтгэсэн ажлын нэгжид ногдох цалингийн үнэлгээг төрийн өмчийн болон төсөвт байгууллагуудын ажиллагсдын цалин хөлсийг Засгийн газраас нэмэгдүүлэх, хэрэглээний зүйлийн үнэ тариф өөрчлөгдөх, ажлын ачаалал хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын хувьд тухайн жилийн бизнес төлөвлөгөө, зорилтот түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

3.2 Салбарын ажиллагсдын цалин хөлсийг хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулж, урт хугацаанд олон улсын жишигт нийцүүлэх чиглэл баримтална. Иргэний нисэхийн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 420,000 төгрөгөөс багагүй байхаар тогтооно.

3.3 Талууд Иргэний нисэхийн салбарын ажиллагсдын цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, тооцоо судалгааг үндэслэн нийтлэг ажил мэргэжлүүдийн тарифт цалинг тогтоох талаар хамтран ажиллана.

3.4 Аж ахуйн нэгж байгууллага болон түүний салбар нэгж татан буугдсан, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр орон тоо нь хасагдсан, бөөнөөр халах, өөр ажилд шилжсэн ажилтанд цалин, хөлс, тэтгэмжийг иргэний агаарын тээврийн салбарт ажилласан жилийг нь харгалзан 3 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно.

3.5 Тэтгэвэрт гарсан ажилтанд иргэний агаарын тээврийн салбарт ажилласан жилийг харгалзан 3-36 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгоно.

3.6 Ажилтныг удаан жил, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор “ажилласан жилийн нэмэгдэл”-ийг олгоно.

3.7 Байгууллагын жилийн эцсийн үр дүнг үндэслэн нийт ажилтнуудад шагналт цалин олгож болно.

3.8 Ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагыг үндэслэн ажилтанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох ажлын байрны жагсаалт гаргаж мөрдөн ажиллана

3.9 Амаржсаны болон ээлжийн амралтаа эдэлсэн эхэд өөрийн хүсэлтийг нь үндэслэн хүүхдийг нь нэг нас хүртэл тухайн байгууллагын хамтын гэрээгээр тохиролцсноор чөлөөтэй байх хугацааны тэтгэмжийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг төлнө. Энэ хөнгөлөлт, тэтгэмж нь нярай хүүхэдтэй ганц бие эцэг, нярай үрчлэн авсан эхэд нэгэн адил хамаарна.

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХӨДӨЛМӨРИЙН НОРМ НОРМАТИВЫН ТАЛААР



4.1 Ажил амралтын цагийн горимыг байгууллагын ажлын онцлогтой уялдуулж зохицуулан баталж мөрдүүлнэ.

4.2 Ажилтны ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 цаг долоо хоногийн ажлын өдрийн ажиллах нийт хугацаа 40 цагаас хэтрэхгүй байна.

4.3 Ээлжинд ажилладаг ажилтны шөнө ажилласан нэг цагийн нэмэгдлийг хэвийн нөхцөлд 800, хэвийн бус нөхцөлд 1000 төгрөгөөс доошгүй байхаар тус тус тооцон олгоно.

4.4 Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдлийг үндсэн, хийснээр нь олгох цалингаас бодож олгохдоо хамтын гэрээгээр дараах хувь хэмжээнээс илүүгээр тогтоон олгоно. Үүнд:

4.4.1 Хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажилладаг бол 10 хувь

4.4.2 Хүйтний улиралд ажилладаг бол 10 хувь

4.5 Ажилтны мэргэжлийг дээшлүүлэх мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх болон өмч хувьчлах, өөрчлөн байгуулах үед ажлын байрны баталгааг хангана.

4.6 Иргэний нисэхийн салбарын нарийн мэргэжлийн ажилтнуудын ажлын байрны баталгааг хангах зорилгоор тухайн ажлын байранд дотоодын ажиллах хүч байгаа тохиолдолд гадаад улс орны ажиллагсдыг авч ажиллуулахгүй байна.

4.7 Ажил олгогч нь аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсаны улмаас ажилтнуудыг цомхтгох, бөөнөөр халах тохиолдолд "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн заасны дагуу мэдэгдэж Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай зөвшилцөнө.

4.8 Ажилтны буруу биш шалтгаанаар сул зогсолт гарвал ажилтанд сул зогсолтын нөхөн олговрыг үндсэн цалингийн 65 хувиас доошгүй хэмжээгээр олгоно.

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА, СТАНДАРТ ХАНГАХ ТАЛААР

5.1 Ажилтанд эрхлэн гүйцэтгэдэг ажлын онцлогийг харгалзан ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгсэл, хор саармагжуулах бүтээгдэхүүн, ариутгах, цэвэрлэх, угаах бодисоор үнэгүй хангахын хамт хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасны жагсаалтыг баталж мөрдүүлнэ.

5.2 Үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас учирсан хохирлыг хуулийн дагуу нөхөн төлбөрийг жил бүр индексжүүлэн нэгээс доошгүй удаа олгоно.

5.3 Ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангах үүднээс жил бүр байгууллагын зардлаар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, ажлын байрны нөхцөлийн үнэлгээг тоног төхөөрөмж нэмэгдэх болон ажлын байрны орчны нөхцөл өөрчлөгдөх тухай бүрт нь байгууллагын зардлаар хийлгэнэ.

5.4 Мэргэжлийн байгууллагуудаас хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн үнэлгээ дүгнэлт гарсан ажлын байруудад ажиллагсдыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн хөнгөлөлт болох ажлын цагийг богиносгож, ээлжийн нэмэгдэл амралтыг олгоно.

5.5 Эрсдэлтэй ажлын байрны жагсаалт гарган, түүний дагуу амь нас, эрүүл мэндийн болон хариуцлагын даатгалд хамруулна.

5.6 Талууд Үндэсний ажил мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолтод ороогүй ажил мэргэжлийг оруулах тал дээр хамтран ажиллана

ЗУРГАА. АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖИЛ БОЛОВСРОЛЫН ТАЛААР



6.1 Ажил үйлчилгээний шаардлагыг харгалзан байгууллагын хөрөнгөөр дотоод болон гадаадын байгууллагуудад мэргэжлийн дээд боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах ажлыг жил бүр төлөвлөгөөний дагуу явуулна.

6.2 Ажилтан хувиараа суралцах тохиолдолд ажилтны хүсэлтийг харгалзан шаардлагатай үед цалинтай болон цалингүй чөлөө олгож ажлын цагийн зохицуулалт хийнэ.

6.3 Ажиллагсдын ажлын байрны баталгааг хангах, хүний нөөцийн төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах үүднээс ирээдүйд шаардлагагүй болох, нэмэгдэл ур чадвар шаардагдах, цомхтголд орж болзошгүй ажлын байрны судалгаа гаргаж, урьдчилан хүний нөөцөө сургах, өөр ажилд шилжүүлэх давтан сургах арга хэмжээ авна.

6.4 Мэргэжил боловсрол сургалтын тухай хуулийн 20.3 зүйлд заасны дагуу ажил олгогч нь мэргэжилтний ажиллах хүчний чадавхийг дээшлүүлэх, мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих зорилгоор, МБСҮЗ болон Салбар зөвлөлийг хувь хэмжээгээр дэмжлэг үзүүлэхийг хамтын гэрээндээ тусгаж болно.

ДОЛОО. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДЛЫН ТАЛААР

7.1 Ажилтнуудад хоол, унааны нэмэгдлийг хоног тутамд бодож олгох ба хэмжээг тухайн үеийн үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан нэмэгдүүлж байна.

7.2 Үндсэн ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж ажилтнуудын шинжилгээний болон үзлэгийн зардлыг ажил олгогч хариуцна.

7.3 Ажиллагсдын орон сууц шинээр худалдан авах, нөхцөл сайжруулах, хөнгөлөлттэй зээл, цалингийн урьдчилгаа авах, гэр, хашаа, хувийн орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг ажил олгогчоос үйл ажиллагааны зардалд төсөвлөн суулгаж шийдвэрлэж байна.

7.4 Ажилтнуудыг мэргэжлийн хариуцлагын болон бусад төрлийн даатгалд ажил мэргэжлээс хамааран ажил олгогчоос даатгуулна.

7.5 Ажилтны төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд нас барсан тохиолдолд мөнгөн тусламж үзүүлнэ.

7.6 Ажилтан ердийн галлагаатай орон сууц гэрт амьдардаг бол ажил олгогчоос жилдээ нэг удаа түлээ түлшний хөнгөлөлт үзүүлнэ.

7.7 Ажилтнуудын гэр орон гал усны болон байгалийн давагдашгүй хүчин зүйл онц ноцтой аюулд учирсан тохиолдолд мөнгөн тусламж үзүүлнэ.


НАЙМ. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ТАЛААР

8.1 Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд заасан эрх, баталгааг хангахын зэрэгцээ ажил олгогч нь:

8.1.1 Аж ахуй нэгж байгууллагууд нь хамтын гэрээ хэлэлцээр хийхэд шаардлагатай мэдээллийг Үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудад тухай бүр өгнө.

8.1.2 Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татварыг бэлэн бусаар хурааж, тухайн сард багтаан Үйлдвэрчний эвлэлийн хороодын дансанд шилжүүлнэ.

8.1.3 Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлийн хороодыг ажиллах нөхцөл бололцоогоор /ерөө, хурал, уулзалт хийх байр, шаардлагатай судалгаа, холбогдох шийдвэр, журам/ хангана.



8.1.4 Иргэний агаарын тээврийн салбарын шугамаар зохиогдох семинар, сургалт, хурал зөвлөгөөнд иргэний нисэхийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн идэвхтэн, сонгуультнуудыг оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

8.2 Үйлдвэрчний эвлэлийн ажлыг хэвлэл, мэдээллээр сурталчлах, хамтарсан үзлэг, сургалт, шалгалт хийх, “Хөдөлмөрийн тухай”, “Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай” болон хөдөлмөрийн харилцаатай холбогдох бусад хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, гишүүдийг Үйлдвэрчний эвлэлийн сургалтад хамруулахад салбарын холбооны албан тоотыг үндэслэн цалинтай чөлөө олгоно.

8.3 Агаарын тээврийн салбарын ажил, үйлчилгээний үнэ тарифыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь ажил олгогчид зохих дэмжлэг үзүүлнэ.

ЕС. НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТАЛААР

9.1 Төрийн захиргааны төв байгууллага Иргэний агаарын тээврийн салбарын хөдөлмөрийн чуулганыг 2 жилд нэг удаа зохион байгуулна.

9.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

9.3 Хүн амыг хамарсан халдварт өвчлөл, тахал гарсан тохиолдолд ажилтнуудын эрүүл мэнд, амь насыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллана.

9.4 Салбарын үндсэн ажилтнуудыг орон сууцаар хангах зорилгоор орон сууц барих, хөнгөлөлттэй зээлд хамруулах хөтөлбөр гаргаж хэрэгжүүлж болно.

АРАВ. ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ТАЛААР

10.1 Хамтын хэлэлцээрт орсон асуудлыг хугацаанд нь биелүүлэх үүргийг гэрээг байгуулсан талууд хариуцна.




10.2 Салбарын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо нь салбарын нийт ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалагчийн хувьд хамтын хэлэлцээрт туссан асуудал бүрийг хугацаанд нь биелүүлэхийг шаардах, хэрэгжилтийн явц байдлыг төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн төлөөлөлд мэдээлнэ.


10.3 Хамтын хэлэлцээр байгуулах явцад болон хэлэлцээрт тусгагдсан асуудлыг биелүүлээгүй үед хөдөлмөрийн хамтын маргаан үүсгэх эрхийг талууд тэгш эдэлнэ.






ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛСАН







ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ: ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

- | | | | |
|----|---|---------------|---|
| 1. |  | Д.Мягмарсүрэн | Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын үүргийг түр орлог гүйцэтгэгч |
| 2. |  | Г.Алтангэрэл | Бодлого, төлөвлөлтийн газрын Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн Санхүүгийн тайлангийн нэгтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн |
| 3. |  | Ө.Одгэрэл | Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт нормативын хэлтсийн ахлах мэргэжилтэн |









- | | | | |
|----|---|----------------|--|
| 4. |  | Ч.Мөнхтуяа | Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| 5. |  | Ө.Мөнгөнжигүүр | Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн |
| 6. |  | Б.Цэнд | Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн |

АЖИЛ ОЛГОГЧДЫГ ТӨЛӨӨЛЖ: ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИД

- | | | | |
|----|---|-------------|--|
| 1. |  | С.Манлай | Иргэний нисэхийн ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Нислэгийн аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын албаны |
| 2. |  | П.Ариунболд | Иргэний нисэхийн ерөнхий газрын Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын дарга |
| 3. |  | Б.Мөнхбат | Иргэний нисэхийн ерөнхий газрын Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газрын Ахлах мэргэжилтэн |
| 4. |  | Н.Ганболд | “МИАТ” ТӨХК-ийн Үйлдвэрлэл эрхэлсэн Тэргүүн дэд захирал |
| 5. |  | Б.Даваадорж | “МИАТ” ТӨХК-ийн Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн |
| 6. |  | Б.Дөлгөөн | “Изинис эйрвэйз” ХХК-ийн Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга |

АЖИЛТНЫГ ТӨЛӨӨЛЖ: МОНГОЛЫН ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗРЫН ТОСНЫ АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ХОЛБОО

- | | | | |
|----|---|--------------|--|
| 1. |  | Б.Рагчаа | Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дарга |
| 2. |  | Р.Батнасан | “МИАТ” ТӨХК-ийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга |
| 3. |  | Б.Энхжаргал | “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга |
| 4. |  | Ө.Дашхорол | Иргэний нисэхийн ерөнхий газрын Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга |
| 5. |  | Ц.Амарсанаа | Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга |
| 6. |  | Д.Атарсайхан | Иргэний нисэхийн ерөнхий газрын Холбоо, навигаци, үйлчилгээний ажилчдын Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга |